БАТЛАВ.

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.НАРАНГЭРЭЛ

НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026.02.24 Дугаар: ТӨАХААГ/20260201069 Зуунмод

1	Үндэслэл	• Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр • Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 05-р хуралдааны 26-р тогтоолын 6 дугаар хавсралтын 9 дэх заалт
2	Зорилго	Иргэдийн ая тухай аялах, амрах нөхцөлийг бүрдүүлж, стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламжийг бий болгоход оршино.
3	Хугацаа	Нийтийн эзэмшлийн талбайд ариун цэврийн байгууламж барих ажлыг захиалагч, гүйцэтгэгч талуудын гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
4	Үнэ	150.000.000 /нэг зуун тавин сая/
5	Эх үүсвэр	Аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /Орон нутгийн төсөв/
6	Байршил	Манзуширын амны тогтсон байршилд
7	Байгууламжийн хэмжээ	Байгууламжийн хэмжээ 6х8 метрээс багагүй байх
8	Байгууламжийн гаднах хийцлэл	Төмөр карказтай байгууламж, сэндвичэн эсвэл хөнгөн блокон бүтээцтэй
9	Бие Засах газрын дотор зохион байгуулалт	1. Эмэгтэй явган суултууртай кабин 4ш 2. Эмэгтэй хүүхдийн сууртууртай кабин 1ш 3. Эрэгтэй явган суултууртай кабин 2ш 4. Эрэгтэй хүүхдийн сууртуултай кабин 1ш 5. Эрэгтэй хөтөвч /шээлтүүр/ 2ш 6. Тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө 2ш /эрэгтэй, эмэгтэй/ 7. Эх хүүхдийн өрөө 1ш 8. Ажилчдын амрах өрөө 1ш 9. Гар угаалтуур /тольтой/ нийт 4ш /1хүүхдийн/ 10. Тусгаарлагч хана, хаалга /кабин бүр 900*1500см-ээс багагүй хэмжээтэй, тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө 1800*1500см-ээс багагүй талбайтай, тасалгаа тус бүр хаалгатай, хувцасны өлгүүр, хогийн сав, ариун цэврийн цаас тогтоогч /Загвар зургийг хавсаргав.
10	Нийтийн ариун цэврийн	1. Нийтийн ариун цэврийн байгууламж нь жилийн дөрвөн улиралд ажилладаг, бага оврийн цэвэрлэх

CamScanner

	байгууламжид тавигдах ерөнхий шаардлага	байгууламжтай байх; /20 м.куб-ээс багагүй багтаамжтай, 100-150 хүн/өдөр/ 2. Нийтийн ариун цэврийн байгууламж барих байршилд гүний худаг гаргах эсвэл хамгийн ойр худгийн эх үүсвэрээс шийдэх; 3. Цахилгааны эх үүсвэрийг нарны эрчим хүч болон төвлөрсөн шугам сүлжээгээр шийдвэрлэх; 4. Байгууламжийн хийц нь цементэн суурьтай, хоорондоо бэхлэгдсэн байх; 5. Нийтийн ариун цэврийн байгууламж нь явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замтай байх; 6. Эрэгтэй эмэгтэй орох хэсгийг тусгаарлаж, тэмдэгжүүлсэн байх; 7. Нийтийн бие засах газрын барилгын хийц, бүтэц, материал зэрэг нь барилга байгууламжид тавигдах барилга угтсралтын болон галын аюулгүй ажиллагааны талаарх норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан байх; 8. Нийтийн бие засах газрын тоноглол нь удаан эдэлгээтэй бат бөх /металл/ байх; Нийтийн бие засах газрын хаяг, тэмдэг, тэмдэглэл нь сайн харагдахаар гэрэлтдэг будаг, эсхүл цацруулагч бүрхэвчтэй хийх; 9. Нийтийн бие засах газар нь галын аюулгүй байдлыг хангасан зохион байгуулалттай, галын аюулгүйн дүрэмд нийцсэн гал унтраах анхан шатны хэрэгсэлтэй байх; 10. Өрөө тасалгаанд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, цонхыг барилгын норм, стандартын дагуу хийх; 11. Болзошгүй гамшгаас сэргийлж, ослын гэрэлтүүлгийг нарны эрчим хүч ашиглан мэдрэгчтэй гэрэлтүүлэхээр хийх; 12. Гаднах орчныг тохижуулах, гэрэлтүүлэг, 2метрээс өндөр 10 ширхэгээс багагүй мод тарих
11	Хяналтын камерын систем	1. Нийтийн бие засах газарт болзошгүй эрсдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор MNS6423:2019 стандартын шаардлага хангасан камерыг хувь хүний нууцад халдахгүй байхаар шийдэн, байгууламжийн гадна талд хяналтын камер байрлуулж, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах; 2. Дуу дүрсний мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн төхник хэрэгсэл байх;
12	Халаалт, агаар сэлгэлт, цахилгаан хангамжид тавигдах	1. Нийтийн бие засах газрын халаалт, агаар сэлгэлтийн тоног төрөөрөмж, агаар дамжуулах хоолой, дулаан тусгаарлалтын хийцийг стандартын шаардлага хангасан материалаар хийх;

CamScanner

	ерөнхий шаардлага	2. Нийтийн ариун цэврийн байгууламжийн агаарын чийгшил, агаарын температурыг стандартын дагуу төлөвлөн хийх; 3. Нийтийн бие засах газрын халаах хэрэгсэл болон дамжуулах хоолойн ил хэсгүүдийн гадаргуугийн хэрэгслийг хамгаалах хаалт төлөвлөж, дамжуулах хоолойг дулаалах; 4. Гаднах цахилгааны хангамжийг тооцоолон шийдвэрлэх;
13	Ашиглалт хамгаалалтын байдал	1. Гүйцэтгэгч тал 3 жилийн хугацаанд эвдрэл гэмтэл, урсгал засварын үйлчилгээг хариуцна.

БОЛОВСРУУЛСАН:
ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН М.ЦЭЭПИЛ

CamScanner

ГАДНАХ ХАРАГДАХ БАЙДЛЫН ЗАГВАР ЗУРАГ



CamScanner

ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ЗАГВАР ЗУРАГ



CamScanner